



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/339

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.5.1 дэх хэсэг, Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын “Орон тоо шинэчлэн батлах тухай” 2021 оны А/276, А/277 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа алба салбаруудын хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, материалыг дүгнэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, тушаалд өөрчлөлт оруулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Х.Болор-Эрдэнэ

Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын менежер

Нарийн бичиг:

Б.Оюунчимэг

Худалдан авах ажиллагааны тасгийн ахлах инженер

Гишүүд:

С.Нацагдорж

Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга

С.Отгонбаяр

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны ерөнхий нягтлан бодогч бөгөөд албаны дарга

Б.Батбаатар

Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дарга

Д.Цэцэгмаа

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны эдийн засагч

Л.Отгонжаргал

“Буянт-Ухаа” нисэх буудлын ашиглалтын хэсгийн дарга

Ц.Цацрал

Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны ахлах нягтлан бодогч

Б.Хүсэлт

Хуулийн хэлтсийн хуулийн мэргэжилтэн

2.

2. Түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 51 дугаар тогтоолын дагуу зохион байгуулж, үр дүнг тухай бүр танилцуулахыг ажлын хэсэг (Х.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Р.Амарбаясгалан)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/270 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ